

**ЖУРАМ БАТЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
БАТЛАХ ТУХАЙ**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2022 оны 01 дүгээр сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

## **ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АУДИТ ХИЙХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээд (цаашид “аудит хийх хуулийн этгээд” гэх)-ийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулна.

### **Хоёр. Аудит хийх хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага**

2.1. Аудит хийх хуулийн этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, аудитын үйл ажиллагааг 2-оос доошгүй жил эрхэлсэн байх

**2.1.2.** Хороо болон Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлсэн чанарын хяналтын шалгалтад хангалттай үнэлгээ авсан байх;

2.1.3. аудитын компани нь 4 ба түүнээс дээш орон тооны аудитортой байх

2.1.4. аудитын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30.0 сая төгрөг ба түүнээс дээш байх

2.1.5. аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх

2.1.6. аудиторууд нь мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээг хийлгэсэн байх

2.1.7. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх журамтай байх;

### **Гурав. Аудит хийх хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг**

3.1. Энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээд нь Хороонд бүртгүүлэх хүсэлтээ дор дурдсан баримт бичгийн хамт цаасан эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ:

3.1.1. энэ журмын 1 дүгээр хавсралтын маягтын дагуу гаргасан бүртгүүлэхийг хүссэн өргөдөл;

3.1.2. энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу бүрдүүлсэн холбогдох баримт бичгүүд.

3.2. Аудит хийх хуулийн этгээд бүртгэлийн хугацаа сунгуулах, оноосон нэр, хаяг, байршил, гүйцэтгэх захирал өөрчлөгдөх тухай бүр Хороонд бүртгүүлэх үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Аудит хийх хуулийн этгээдийг бүртгэхээс татгалзах, хасах, бүртгэлийн хугацаа, бүртгэл хөтлөх, мэдээлэх**

4.1. Хороо энэ журмын хавсралт 2-т заасан баримт бичгийн бүрдэл болон энэ журмын 2 дугаар зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангасан гэж үзвэл ажлын 20 хоногийн дотор бүртгэнэ.

4.2. Энэ журмын 4.1-т заасан бүртгэлийн хугацаа нь Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн аудитын хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.

4.3. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан аудит хийх хуулийн этгээдэд албан бичгээр хариу мэдэгдэнэ.

4.4. Хороонд аудит хийх хуулийн этгээдийг дор дурдсан үндэслэлээр бүртгэхээс татгалзана:

4.4.1. энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагын аль нэгийг нь хангаагүй;

4.4.2. Хорооноос баримт бичгийн бүрдэл хангуулах тухай албан бичгийг хүсэлт гаргагчид хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй.

4.5. Хороонд бүртгэгдсэн аудит хийх хуулийн этгээдийг дор дурдсан үндэслэлээр бүртгэлээс хасна:

4.5.1. Өөрийн хүсэлтээр;

4.5.2. Хороо ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

4.5.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.5.4. санхүүгийн тайланг хуурамчаар баталгаажуулсан нь нотлогдсон;

4.5.5. Хороо болон санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас хэрэгжүүлсэн чанарын хяналтын шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан;

4.4.6. бодит бус дүгнэлт гаргасан, дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж, олон улсын стандартыг зөрчсөн, мэргэжлийн ноцтой алдаа гаргасан, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүссэн;

4.5.7. энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагуудын аль нэгийг болон бүгдийг хангахгүй болсон;

4.5.8. холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон.

4.6. Энэ журмын 4.5.7-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан аудит хийх хуулийн этгээд бүртгэлээс хасагдсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

4.7. бүртгүүлэхээр хүсэлт гаргасан болон бүртгэлтэй хуулийн этгээд энэ журмын 4.5.2-т заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан аудит хийх хуулийн этгээдэд ажиллаж байсан зохих мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагаас буруутай нь тогтоогдсон аудиторыг мөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар авч ажиллуулахыг хориглоно.

4.9. Аудит хийх хуулийн этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан тухай Хороо ажлын 10 хоногт багтаан өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

4.10. Хороо бүртгэгдсэн аудит хийх хуулийн этгээдэд үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын дагуу явагдаж байгаа эсэхэд аудитын чанарын хяналт тавьж, хяналт шалгалт хийнэ.

--- ооОоо ---

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний өдрийн .... дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ын хавсралт 1

## АУДИТ ХИЙХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭР БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

### **-Тэмдэглэл-**

*Өргөдөл гаргагч хуулийн этгээд нь өөрийн бланкыг ашиглан ирүүлэх маягтыг бүрэн гүйцэд бөглөж, албан ёсны нэр, хаягийг тодорхой бичих ёстой.*

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
<b>Хуулийн этгээдийн мэдээлэл</b>						
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр						
Үйл ажиллагааны чиглэл/ ангилал:						
Регистрийн дугаар						
Улсын бүртгэлийн дугаар:						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						
Тусгай зөвшөөрлийн дугаар:						
Сангийн сайдын тушаал/тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа						
Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа						
Бүртгэлийн төрлийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавих						
<input type="checkbox"/> Бүртгэл хийлгэх	<input type="checkbox"/>	Хаяг, байршлын өөрчлөлт				
<input type="checkbox"/> Бүртгэлийн хугацааг сунгуулах	<input type="checkbox"/>	Гүйцэтгэх удирдлага солигдох				
<input type="checkbox"/> Бүртгэлээс хасуулах	<input type="checkbox"/>	Аудиторын өөрчлөлт				
<input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх						
Холбоо барих утас	Суурин		Гар утас		Факс	
Цахим хаяг:						
Цахим хуудас						

<b>Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл</b>							
Хуулийн этгээдийн хаяг байршил (дүрэмд тусгагдсан хаяг байршилын мэдээлэлтэй ижил байх)	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/> Бусад /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./							
Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх.							
<b>Боловсон хүчний мэдээлэл</b>							
Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан /гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, хувь нийлүүлсэн гишүүд, дотоод хяналтын ажилтнууд/:							
№	Овог, нэр	Одоогийн эрхэлж буй ажил	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Хуулийн этгээдэд эрхэлж буй албан тушаал		
Тэмдэглэл: Албан тушаалтан бүрийг бичих.							
Аудит хийх эрхтэй аудиторовн тоо		Үндсэн		Туслах		Гэрээт /Бусад ажилтан/	
Аудиторын овог нэр		Регистрийн дугаар		Оршин суух хаяг, холбоо барих утас		Тухайн хуулийн этгээдэд ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар хугацаа	
						ММНББИ-ийн батламжийн дугаар	
						Төрөлжсөн сургалтын нэр, огноо, гэрчилгээний дугаар	
1/							
2/							
3/							
4/							
5/							
<b>Өөрчлөлтийг бүртгүүлэх мэдээлэл /Журмын хавсралт 2 заасан холбогдох бүхий баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ/</b>							
<b>Оноосон нэр өөрчлөгдсөн</b>							
Оноосон нэр өөрчлөх шийдвэрийн огноо, дугаар				_____		_____	
				/он/		/сар/	
						/өдөр/	
				/дугаар/			
Хуулийн этгээдийн шинэ нэр (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичих)							
Хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөх болсон шаардлага							

Гүйцэтгэх удирдлагын өөрчилсөн мэдээлэл							
№	Гүйцэтгэх албан тушаал	Томилсон шийдвэрийн огноо, дугаар	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Шалтгаан	
Тэмдэглэл: Хүн тус бүрийг бичих							
Аудитор өөрчилсөн мэдээлэл							
№	Аудиторын овог нэр	Регистрийн дугаар	Томилсон шийдвэр	Тухайн хуулийн этгээдэд ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар хугацаа	ММНББИ-ийн батламжийн дугаар	Төрөлжсөн сургалтын нэр, огноо, гэрчилгээн ий дугаар	Шалтгаан
1							
2							
3							
4							
Шинэ хаяг, байршлийн өөрчлөлтийн мэдээлэл							
Хуулийн этгээдийн дүрэмд шинэ хаяг байршлыг тусгах шийдвэрийн огноо, дугаар				_____ он _____ сар _____ өдөр дугаар _____			
Хаяг байршил		Аймаг/ хот					
		Сум/дүүрэг					
		Баг/хороо					
		Гудамж, байр					
		Тоот					
		Холбоо барих утас					
Тэмдэглэл: Хуулийн этгээдийн шинэ хаяг, байршил нь тухайн хуулийн этгээдийн дүрэмд тусгагдсан байх.							

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа эрхийн нотлох баримтын бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдээр бүртгэнэ үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

Хуулийн этгээдийн  
Тэмдэг

\_\_\_\_\_  
/Гарын үсэг/

/\_\_\_\_\_/

/Гарын үсгийн тайлал/

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ын хавсралт 2

**БҮРТГЭЛИЙН ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ  
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
<b>Нийтлэг</b>		
1	Өргөдөл гаргасан албан бичиг	
2	Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /журмын 1 дүгээр хавсралт/	
<b>Аудит хийх хуулийн этгээдийг бүртгүүлэх</b>		
1	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	
2	Дүрмийн хуулбар	
3	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	
4	Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлсэн чанарын хяналтын шалгалтад хангалттай үнэлгээ авсныг нотлох баримтын хуулбар	
5	Аудитын тухай хууль болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шаардлагыг тухайн жил хангаж ажилласан талаар ММНБИ-д батлагдсан загварын дагуу тайлагнадаг тухай тодорхойлолт	
6	виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд гүйцэтгэх аудит журамтай байх;	
<b>Бүртгэлийн хугацааг сунгуулах</b>		
1	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар	
2	эрх бүхий төрийн байгууллагаас зохион байгуулсан чанарын хяналт шалгалтаар хангалттай үнэлгээ авсныг нотлох баримт	
3	Аудитын тухай хууль болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шаардлагыг тухайн жил хангаж ажилласан талаар ММНБИ-д батлагдсан загварын дагуу тайлагнадаг тухай тодорхойлолт	
<b>Өөрийн хүсэлтээр бүргэлээс хасуулах</b>		
1	Бүртгэлээс хасуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн хуулбар	
2	Өргөдөл гаргах үеийн санхүүгийн тайлан	
<b>Оноосон нэр өөрчлөгдсөнийг бүртгүүлэх</b>		
1	Оноосон нэр өөрчлөх үндэслэл бүхий хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрийн хуулбар	

2	Өөрчлөлт орсон дүрмийн хуулбар	
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас	
4	Улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын хуулбар	
<b>Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгүүлэх</b>		
1	дэлгэрэнгүй анкет /журмын 3 дугаар хавсралт/	
2	Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх тухай шийдвэр	
3	Гүйцэтгэх удирдлагын иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар	
4	гүйцэтгэх удирдлагаар томилогдсон этгээд нь сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай тухайн этгээдээс гаргасан тодорхойлолт	
<b>Аудиторын өөрчлөлтийг бүртгүүлэх</b>		
1	дэлгэрэнгүй анкет /журмын 3 дугаар хавсралт/	
2	аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийн хуулбар	
3	нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа	
4	үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар	
5	мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний хуулбар	
6	мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн тодорхойлолт	
<b>Хаяг, байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх</b>		
1	Хуулийн этгээдийн дүрэмд шинэ хаяг байршлыг тусгах шийдвэрийн хуулбар	
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн өөрчлөгдсөн хаяг, байршилтай тухайн хуулийн этгээдийн дүрэм	
3	Хаяг, байршил бүртгүүлсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	